

Б.ЛХАМСҮРЭН - МОНГОЛЫН НАМ, ТӨРИЙН УДИРДАХ АЛБАНД

*О.Эрдэнэчимэг**

Академич, түүхийн шинжлэх ухааны доктор, манай нам, төрийн ахмад зүтгэлтэн Бадамын Лхамсүрэн гуайн 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд, энэ агуу хүний тухай, оюуны өндөр потенциалаа улс эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө зориулан хөдөлмөрлөж байсан тухай илтгэл тавих болсондоо туйлын баяртай байна.

Миний бие Лхамсүрэн гуайг мэдэх болсноор хэдий удаагүй боловч түүний тухай хамт ажиллаж байсан нөхдийн дурсамж, дурьдатгал, ярианаас эгэлгүй хүн болохыг олж мэдсэнээр энэ буурлыг хүндэтгэх, бишрэх сэтгэл аяандаа төрснийг энэ дашрамд хэлэхийг хүсэж байна.

Сартад овогтой Бадамын Лхамсүрэн нь хөдөлмөрийн гараагаа 1938 онд бага сургуулийн багшаар эхэлж, 1947-1954 онд МАХН-ын Төв Хороонд лектор, Гадаад явдлын Яамны ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын референтээр ажиллаж байжээ.

1959 онд ГЯЯ-ны орлогч сайд, 1959-1962 онд БНМАУ-ын СнЗ-ийн даргын орлогч, 1962-1972 онд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, 1953 оноос Улс төрийн Товчооны орлогч гишүүн, 1975-1981, 1984-1988 онд Прага дахь “Энх тайван социализмийн асуудал” сэтгүүл дэх МАХН-ын төлөөлөгч, 1981-1984 онд Нийгмийн ухааны институтын захирал, 1988-1990 онд МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөгчөөр ажиллаж байжээ.

Энэ бүгдээс тунгаан эргэцүүлэхэд түүхийн шинжлэх ухааны доктор, академич Б.Лхамсүрэн нам, төрийн өндөр албыг хашиж нийгмийн оюун ухааны талбар, юуны урьд МАХН-ын үзэл, онолын салбарт тасралтгүй ажиллаж иржээ.

Б.Лхамсүрэн МАХН-ын хоёр удаагийн программ, таван удаагийн их хурлын үндсэн баримт бичгийг боловсруулахад оролцож, БНМАУ-ын гадаад бодлогын асуудлыг манай оронд анх удаа эрдэм шинжилгээний талаас тусгайлан судалж олон улсын талбарт идвэхтэй үйл ажиллагаа явуулж байв.

*О.Эрдэнэчимэг - Сургалт судалгааны “Прогноз” төвийн захирал, доктор (Ph.D)

1950 онд НТХ-ны шийдвэрээр Гадаад явдлын яамны Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан ба тухайн үед манай улсын гадаад харилцаа мэдэгдэхүйц өргөжсөнтэй холбогдуулан Гадаад харилцааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөж, боловсон хүчнээр бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж байжээ. Б.Лхамсүрэн: Өөрийн дурсамждаа “ГЯЯ-нд ажилласан жилүүд бол миний хувьд олон улсын харилцааг судлах, дипломат баримт бичгийг боловсруулах, дипломат албанд суралцах он жилүүд байв. Үүнд Улаанбаатар хотын намын хорооны дэргэд байгуулагдсан Марксизм-Ленинизмийн оройн их сургуульд олон улсын харилцааны түүхийн хичээлийг зааж, энэ зорилгоор өөрийгөө бэлтгэх ажил надад их тустай байсан. Энэ чиглэлээр судалгааны ажил хийх санаа анх төрж, ийм ажлын арга техникийн үндсийг эзэмшихийг чармайж байсан. 1951 онд өөртөө мөрдлөг болгохоор бэлтэгсэн нэг материалд “Бусдын санаа, хуучин баримтлалд шүүмэлзлэлтэй хандаж, аливааг өөрийн санаа бодлын үүднээс авч үзэх хэрэгтэй” гэж онцлон тэмдэглэж билээ” гэсэн дурсамжаас харахад өөртөө өндөр шаардлага тавьдаг, шинийг эрэлхийлж аливаа зүйлд өөрийн байр суурьтай байхыг эрмэлздэг болох нь харагдаж байна.

1954 оны намар Москва дахь Нийгмийн ухааны Академийн аспирантурт шинэ түүхийн мэргэжлээр элсэн суралцаад 1958 онд “БНМАУ-ын гадаад бодлого ба дэлхийн II дайнаас хойш түүний гадаад харилцаа өргөжсөн нь” сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалсан нь тэр үед манай улсын гадаад харилцааг тусгайлан авч үзсэн анхны судалгаа байжээ.

1959 онд Б.Лхамсүрэнг Сайд Нарын Зөвлөлийн соёл гэгээрэл хариуцсан орлогчоор томилж ажиллуулжээ.

Сайд Нарын Зөвлөлийн хариуцах ажлын хүрээ өргөн, бүх шатны сургууль, соёл боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл мэдээлэл, эрүүлийг хамгаалах, биеийн тамир спорт, шашин, сүм хийдийн зэрэг нийгмийн хүрээний бүхий л салбарыг хариуцан ажиллаж байсан байна.

Сайд Нарын Зөвлөлийн орлогч дарга болмогц эн тэргүүнд тулгарсан том ажил бол хүн амыг эрүүлжүүлэх кампанит ажил байжээ. Энэ ажлыг зохион байгуулах улсын онцгой комиссыг толгойлж 4 жил ажилласан нь МАХН-аас улс орныхоо төлөө гүйцэтгэсэн гавъяат үйлсүүдийн нэг болох хүн амаа эрүүлжүүлэх ажилд гар бие оролцож удирдаж, зохион байгуулж байсныг гэрчилнэ.

Улс орныхоо өмнө эхлээд бүх хүнийг бичиг үсэгтэй болгох, сургуулийн насны бүх хүүхдэд анхан шатны, дараа нь бүрэн бус, эцэст нь бүрэн дунд боловсрол заавал үзэл баримтлалыг боловсруулах, дээд боловсролтой үндэсний сэхээтнийг бэлтгэх дэс дараатай тууштай бодлого явуулахад түүний оруулсан хувь нэмэр багагүй болох нь ойлгомжтой.

Б.Лхамсүрэн МАХН-ын XIV Их хурлаас НТХ-ны бүрэлдэхүүнд оржээ. Нам, төрийн бодлогыг боловсруулан гаргахад шийдвэрлэх үүрэгтэй энэ байгууллагад таслах эрхтэй гишүүн болсноор намын амьдралын чухал чухал асуудалд нийгмийн ашиг сонирхлын үүднээс зарчимч байр суурь эзлэх өндөр хариуцлага ноогдсон нь ойлгомжтой.

Тухайн үед эгзэгтэй асуудал цөөнгүй байсан ба хамгийн ноцтой нь нам, улсын дотор нэг хүнийг тахин шүтэж байсантай холбоотой асуудлууд байсан гэж түүний дурсамжинд өгүүлжээ.

Б.Лхамсүрэн нь НТХ-ны Улс төрийн Товчооны шийдвэрээр, 1933-1941 онуудад НАХЯ-ны байгууллагын ажилд гарсан алдаа завхралыг шалгах НТХ-ны комиссын бүрэлдэхүүнд оролцон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн материалтай танилцаж, комиссын илтгэл бичих ажлыг гүйцэтгэснээр манайд нэг хүнийг тахин шүтэж байсны хор уршгийг гүйцэд илчлэн арилгах шаардлагатайг хатуу ойлгосон гэж өгүүлжээ.

Б.Лхамсүрэн МАХН-ын ТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргаар 1962 оны 9 дүгээр сард сонгогдоод намын үзэл суртлын бүхий л ажлыг бүтээн байгуулалтын үйлсэд дөхмийг үзүүлэх чиглэлээр ажил хэрэгч, аядуу голдиролд оруулах, үүний тул үзэл суртлын бүхий л салбарын байдлыг нягталж, шийдвэрлэх гол гогцоо асуудал дээр анхаарлыг төвлөрүүлэх хэрэгтэй гэж үзэж ажиллажээ.

МАХН-ын түүхийг бичих, "МАХН-ын түүхийн төслийг" хянан боловсруулах асуудал тухайн үеийн нэн тулгамдсан асуудал байжээ. 1955 оны 12 дугаар сард МАХН-ын Төв Хорооны дэргэд Намын түүхийн институт байгуулагдаж, МАХН-ын түүхийн сурах бичиг зохиох бэлтгэл ажилд орсон байна.

1956-1958 онд намын түүхийн сурах бичгийн төлөвлөгөөг эрдэм шинжилгээний ажилтнуудаар хэлэлцүүлэн түүний дагуу бүлгүүдийг тэднээр хуваарилан бичүүлж, гарсан төслүүд дээр санал солилцуулж байжээ. Намын түүхийн олонхи асуудал дээр зохиогчдийн санал үндсэндээ нэгдмэл байсан боловч намын шинж чанар хэдийгээс марксист нам болсон, барууны хэлбэрэл, хувьсгалын үе шат, төрийн

шинж чанар, намын удирдах зүтгэлтнийг үнэлэх зэрэг асуудал дээр зүй ёсны маргаан гардаг байжээ.

УТТ-ны 1963 оны 217-р тогтоолоор намын түүхийг редакторлох комиссыг Б.Лхамсүрэнгээр ахлуулан Б.Ширэндэв, Б.Балдоо, Л.Санжаа, Б.Түдэв нарын бүрэлдэхүүнтэй баталжээ. Ингэж 1967 онд "МАХН-ын товч түүх" нэртэйгээр намын түүх анх хэвлэгдэн гарчээ.

МАХН-ын түүхийн 2 дахь хэвлэл 1970 онд, 3 дахь хэвлэлийг 1985 онд мөн Б.Лхамсүрэнгээр ахлуулсан бүрэлдэхүүнтэй комисс редакторлон гаргажээ.

Ингэж Б.Лхамсүрэн МАХН-ын түүхийг бичилцэхэд бусад эрдэмтдийн хамт гар бие оролцсон төдийгүй голлох үүрэг ролийг гүйцэтгэсэн байна.

Б.Лхамсүрэн гуай өөрийн дурдатгалдаа "Бид тухайн үеийн намын улс төр, үзэл суртлын баримтлалын хүрээнд мэдлэг оюун хүч чадлаа дайчлан гаргасан бүтээлээ хэзээ ч бүрэн төгс болсон гэж үзэж байгаагүй" юм.

Товч түүхэнд үйл явдлыг бүрхэгдүүлсэн, өрөөсгөлдүүлсэн зүйл, нэн ялангуяа намын зүтгэлтнүүдийг үнэлэх, үйл ажиллагааг тодорхойлох талаар багагүй дутагдал байгааг мэдэрсээр байсан. Ийм дутагдал доголдлыг давж, түүхэн бодитой үнэнийг тусгахад гол бэрхшээл нь нам, төрийн олон зүтгэлтэн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн, тэдний бодитой үйл ажиллагааны тухай материал үрэгдсэн буюу Х.Чойбалсангийн тусгай фондод хаалттай байсан, намын үүсэл, хөгжил тэмцэлтэй холбоотой захидал харилцаа, мэдээллийн ихэнхи материал Коминтерний ба ЗХУ-ын бусад архивуудад хаалттай байсан явдал бөгөөд тэдгээрийг 90-ээд оноос хойш нээж ашиглах боломжтой болсон гэжээ.

Б.Лхамсүрэн нь МАХН-ын дөрөв дүгээр программын нэг дүгээр хэсэгт орох намын түүхэн замналын хэсгийг НТИ-ийн судлаачидтай хамтран боловсруулснаас гадна, программын соёлын байгуулалт, үзэл суртал, хүмүүжлийн ажлын тухай хэсгүүдэд зарим засвар хийхэд оролцжээ.

Б.Лхамсүрэн НТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргаар ажилласан 1962-1972 он бол манай орны хөгжлийн дотоод, гадаад нөхцөл эгзэгтэй, намын үйл ажиллагаанд бэрхшээл учирч байсан нарийн төвөгтэй үе байсан гэж өөрийн дурсамжинд дурьдсан байна.

Ийм нөхцөлд онолын сэтгэлгээг хөгжүүлэх, үзэл суртлын ажлын агуулгыг баяжуулах, амьдралтай холбох, арга хэлбэрийг нь бүтээлч, үр өгөөжтэй болгох, үзэл суртал хүмүүжлийн арга хэмжээний нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэхийг гол зорилт болгон тавьж, зорилгоо биелүүлэхийн тулд өөрийнхөө бүх бололцоог дайчлан ажиллаж байжээ.

1960-1970 оны заагаар НТХ-ны удирдлагуудын дотор зарим асуудлаар санал зөрөлдөөн гарч даамжрах хандлагатай байсан ба энэ талаар өөрийн байр суурийг илэн далангүй илэрхийлдэг байжээ.

Ийнхүү намын үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргын ажлыг бүтэн 10 жил тогтвортой хийгээд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөн ЗХУ-д докторантурт суралцахаар болсон.

1975 онд докторын зэрэг хамгаалсны дараа МАХН-ын ТХ-ны “Энх тайван социализмын асуудал” сэтгүүлийн намын төлөөлөгчөөр томилжээ.

1981 оны 4 дүгээр сараас УГТ-ны шийдвэрээр НТХ-ны дэргэдэх Намын түүхийн институтийн захирлаар томилогдон ажиллажээ.

Энэ шийдвэр намын онолын сэтгэлгээг хөгжүүлэхийг чухалчлан үзэж Лхамсүрэн гуайд өндөр итгэл найдвар хүлээлгэсний илэрхийлэл.

Б.Лхамсүрэн нь НТИ-ийн захирал болсноор онол эрдэм шинжилгээний энэ чухал төвийн нэр хүнд үйл ажиллагааг шаардлагын түвшинд хүртэл дээшлүүлэх, үүний тулд намын түүхээ гүнзгийрүүлж судлахын зэрэгцээгээр намын өмнө тулгарсан онолын асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах чиглэлээр ажиллах, боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх зорилт тавин ажиллажээ.

Үүнийг хамт ажиллаж байсан түүхийн ухааны доктор, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн Б.Сумьяагийн өгүүлснээс ч харж болох юм. Б.Лхамсүрэн нь 1981 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн Институтийн захирлаар томилогдон ирмэгцээ түүнийг Нийгмийн ухааны институт болгон өөрчлөн байгуулж, намын байгуулалт, социалист байгуулалтын онолын хэлтсүүдээр өргөтгөж, тэдгээрийг дотоод, гадаадын их, дээд сургууль, аспирантур төгссөн залуусаар бэхжүүлж эхэлсэн юм. Түүний удирдсан Нийгмийн ухааны институтэд чөлөөт, шинэ сэтгэлгээ, олон ургальч үзэл ердийн хэм хэмжээ болж байв. Уг институтийн нилээд олон судлаач Монголын нийгэм болон МАХН-ын шинэчлэлийн бодлогыг боловсруулахад идэвхтэй

оролцсон. Тэдний нилээд нь эдүгээ манай орны нийгмийн ухааны нэрт эрдэмтэд болж, зарим нь шинжлэх ухааны шинэчлэлийн шинэ нөхцөлд нам, улс, төрийн хариуцлагатай алба хашсаар байна гэжээ.

Б.Лхамсүрэн нь НТИ-ийн захирлаар ажиллаж байхдаа НТХ-ны удирдлагын үйл ажиллагаанд хэвийн биш байдал газар авсныг анхааран ажиглажээ. Энэ бүгдэд Б.Лхамсүрэн өөрийн гэсэн байр суурьтай, шүүмжлэлтэй ханддаг байсан ба 1982 онд хуралдсан НТХ-ны бүгд хурлаар Б.Ширэндэвийг НТХ-ны бүрэлдэхүүнээс, УТТ-ны орлогч гишүүнээс Б.Лхамсүрэнг чөлөөлжээ. Тус бүгд хурлын дараа А.И.Филатова “Б.Лхамсүрэн бол засаршгүй үндсэрхэг үзэлтэн” гэж хэлж байснаас харахад, намын боловсон хүчний бодлогод улс төрийн тоглоом зонхилох болж намын удирдлагын түвшинд нам, улсын эрх ашигт харш элдэв зөрчил тэмцэл өрнөж, зарим хүмүүс ая тал засах, хардлага сөрдлэгийг дэвэргэх, хутган үймүүлэх явдлыг албан тушаал ахих арга болгож байсны илрэл гэлтэй.

Ингэж Б.Лхамсүрэн гуай нэг үед удирдлагадаа итгэгдэн, нэг үе сэжиг төрүүлэн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны бүрэлдэхүүнд нэг орж, нэг гарч, “засаршгүй үндсэрхэг үзэлтэн” болон ажиллаж хөдөлмөрлөж байсан нь тэр улс эх орныхоо хөгжил дэвшилд өөрийн оюун ухаан авъяас билгээ зориулж байсан жинхэнэ “хугараагүй ноён нуруу” болохыг харуулж байна.

Б.Лхамсүрэн нь 80-аад оны сүүл 90-ээд оны эхэн үед МАХН-ыг өөрчлөн шинэчлэх үйл явцад ч өөрийн гэсэн байр суурьтай оролцож байжээ.

Дэлхийн социалист системд багтаж байсан олон оронд нийгмийн ардчилсан өөрчлөлт янз бүрийн хэлбэрээр явагдаж, эхэлсэн ба 80-аад оны сүүлчээр манай оронд энэ үйл явц өрнөсөн.

МАХН-ын нийгэмд эзэлж байсан байр суурь үндсээрээ өөрчлөгдөж, намыг шинэчлэх үйл явц өрнөхийн зэрэгцээгээр хуучин нам, төр засагт өндөр алба хашиж байсан тэр дотроо Б.Лхамсүрэн гуайг Ю.Цэдэнбалын “тойрон хүрээлэгч” хэмээн нэрлэж хуулийн байгууллагад татаж шалгаж байжээ.

Гэвч энэ бүхэн нь нийгмийн ороо бусгаа цагийн өнгө аясаар савласангүй үнэн мөнөөрөө тогтоогдсон байна.

Б.Лхамсүрэн гуайн намтар түүхээс харахад тэрээр цаг үеийнхээ залуучуудын бахархал, үлгэр дууриал, төр засаг, намын шилдэг боловсон хүчин байсан бөгөөд хойч үеийнхэндээ үлгэр дууриалал болох тодорхой арвин баялаг намтар түүхтэй хүн юм.